



2019 оны 11 дүгээр сарын 14
№43/1096/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Эрүүл мэндийн тухай хуульд
нэмэлт оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын Үндсэн хуульд
оруулах нэмэлт, өөрчлөлтийн
төслийг гурав дахь хэлэлцүүлэгт
бэлтгэх үүрэг, хугацаа
тогтоох тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол**

**Сонгуулийн тухай хуулийн
12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь
хэсэг, Монгол Улсын Их Хурлын
2019 оны 22, 23 дугаар тогтоол
Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
эцэслэн шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

368. Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт соёрхон батлах тухай 1602

369. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр болон зээлийн гэрээ соёрхон батлах тухай 1603

370. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 1603

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

371. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 77 1604

372. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 82 1605

373. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 83 1605

374. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 84 1606

375. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 85 1606

376. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Дугаар 86 1607

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

377. Цэргийн дээд цол олгох тухай Дугаар 181 1608

378. Журамд нэмэлт оруулах тухай Дугаар 186 1608

379. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 190 1609



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

- | | | | |
|------|--|-----------|------|
| 380. | Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 03 | 1609 |
|------|--|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | | |
|------|---|--|------|
| 381. | Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлт | | 1625 |
| 382. | Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр | | 1628 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХАВСРАЛТ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БОЛОН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль” төслийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр болон Зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/35¹ дүгээр зүйл:

**“35¹ дүгээр зүйл. Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг,
шинжилгээ, оношилгоо**

35¹.1. Монгол Улсын иргэнийг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн товлосон хугацаанд хамруулна.

35¹.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

35¹.3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд



хамрагдаагүй энэ хуулийн 35^{1.1}-д заасан хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

2/43 дугаар зүйлийн 43.2.10 дахь заалт:

“43.2.10.энэ хуулийн 35^{1.1}-д заасан хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд товлосон хугацаанд хамрагдах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурал 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очироос 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “2.Төрийн худалдан авах ажиллагааны газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21” дэх дугаарыг “3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Төрийн худалдан авах ажиллагааны газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24^д дүгээр зүйлийн 24^д.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл тогтоож, гурав дахь хэлэлцүүлгийг хийх бэлтгэл ажлыг хангахыг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг /Ө.Энхтүвшин/, Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус даалгасугай.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар иргэдэд мэдээлж, тайлбарлан таниулахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар
хот

Цэргийн дээд цол олгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 182 дугаар зарлигаар батлагдсан Дээд офицерын албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, бригадын генерал Довчинсүрэнгийн Ганзоригт хошууч генерал цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 30 дугаар зарлигаар баталсан “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ын Хоёрдугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 2.1.24 дэх заалтыг нэмсүгэй:

2.1.24. Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн олон улсын болон үндэсний хөтөлбөр, төсөлд хамрагдах, оролцох.

2. Мөн журмын 2.1 дэх хэсгийн 2.1.3 дахь заалтын “олон нийтийг оролцуулах” гэсний дараа “, энэ хүрээнд Олон нийтийн дэд зөвлөлийг ажиллуулж болно” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 10 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 171 дүгээр зарлигаар баталсан “Чингис хаан” одонд нэр дэвшүүлэх, шагнах журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “иргэнийг” гэснийг “хамтлаг, иргэн, хуулийн этгээдийг” гэж, 3 дугаар зүйлийн 3.3, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дэх хэсэг, 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.2 дахь заалтын “иргэн” гэснийг “хамтлаг, иргэн, хуулийн этгээд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн” гэснийг “Монгол Улсын болон гадаадын хамтлаг, иргэн, хуулийн этгээд” гэж, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсгийн “иргэнд” гэснийг “хамтлаг, иргэн, хуулийн этгээдэд” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

**Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1,
12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны
22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 11.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат, Ш.Цогтоо, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ш.Солонго, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.



Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Ууганбаяр болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч хэлэлцээд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22, 23 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар тогтоолыг гарган ирүүлсэн тул уг маргааныг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар дахин хянан эцэслэн шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Ганхуяг Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоол нь дараа дараагийн зарчмын хувьд буруу шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт энэ оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын нөхөн сонгууль хийхээр товлож, 287 сая гаруй төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас, үнэн хэрэг дээрээ ард түмний халааснаас гаргахаар шийдвэрлэсэн нь дээр дурдсан буруу шийдвэрээс үүдэлтэй шууд хор хохирол юм. Хууль зөрчин зарласан энэ сонгуульд 11 нам оролцохоор бүртгүүлсэн ба намын болон нэр дэвшигчдээс нэмж гаргах зардлыг тооцвол уг шийдвэр эрүүл ухааны аливаа хэм хэмжээнээс хэтрэн гарсан байна.

... Дээрх хууль бус тогтоолдоо үндэслэн гаргасан Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг шууд зөрчсөн байна. ...Төр нь улс орноо хөгжүүлэх, ард түмнээ элбэг хангалуун, амар жимэр амьдруулах зорилгоор буюу нийгмийн хөгжлийг хангахын тулд эдийн засгийг удирдах учиртай. Гэтэл Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр гаргаж түүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олон зуун сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байгаа нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгод нийцэхгүй байна. ... Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын төлөөллийн тухай ухагдахуун бол

“нэг хүн”-д хамаарах хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны ойлголт биш харин тогтолцоо, зохион байгуулалт буюу “төлөөлөгчдийн байгууллага” болох Улсын Их Хуралд шууд хамаарах ойлголт болохыг учирлан тайлбарлаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна. **Мөн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр:** “Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолыг холбогдох хуульд нийцүүлэн гаргаагүйгээс Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөн” гэсэн нэмэгдүүлсэн шаардлага гаргаж холбогдох тайлбарыг хийжээ.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Ууганбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээллэдээ:

“... Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг Улсын Их Хурал товлон зарлахаар хуульчилсны дагуу Монгол Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн товлон зарлаж, Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон байна. ...

Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр улс төрийн нам нь үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог. Гэтэл Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуульд “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.” гэж хуульчилсан нь санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын



дээд шүүхэд бүртгүүлээгүй нам нь бусад улс төрийн намуудтай ижил тэгш эрхтэйгээр Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах сонгуульд оролцох эрхийг хязгаарлаж байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж хуульчилсан ба Сонгуулийн тухай хуульд зааснаар санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлээгүй нам Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд оролцох нэр дэвшүүлэх, сонгогдох эрхийг энэхүү органик хуулиар хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэж хуульчилсан ба тухайн намаас дээрх Үндсэн хуульд заасан шаардлагыг хангасан хүнийг Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхээр байтал Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцуулахгүй байх, нэр дэвшүүлэхээс татгалзах нөхцөл байдал үүсч байна.

Энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг, мөн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, төрийн бүхий л үйл хэрэгт ард түмний оролцоог хангах, иргэнийг нам, улс төрийн үзэл баримтлалаар ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломжийг бүрдүүлэх Үндсэн хуулийн суурь зарчим, Үндсэн хуулиар бий болгосон иргэний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн байна.

... Мөн Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийг товлон зарлахдаа уг нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даагчийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг нэгдүгээрт, органик хуулиар хязгаарлаж, хоёрдугаарт, улс төрийн нам, эвсэл байгуулах, сонгуульд оролцох эрхийн хууль зүйн болон бусад баталгааг хангаагүй нь Үндсэн хуулийн ноцтой зөрчил болно. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэж хуульчилжээ.

Монгол Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2019 оны 2 дугаар сарын 10-ны өдөр товлон зарласан ба санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон билээ. Гэтэл энэхүү 2 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд 140 хоног болж байгаа ба нам, эвсэл нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцохын тулд 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлага Сонгуулийн хуулиар тавигдсан юм.

Монгол Улсын Их Хурал энэхүү Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлахдаа улс төрийн нам, эвсэлд хуулиар биелэх боломжгүй шийдвэрийг гаргаж, улмаар Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох эрхийг Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгээр хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг болон Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн хариу тайлбарт:

“... Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад Монгол Улсын иргэн нь “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...” гэж заасан байдаг. Гэтэл Хэнтий аймгийн 42 дугаар тойргийн 17450 иргэд, сонгогчид төрийн эрх барих дээд байгууллагад 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс өнөөдрийг хүртэл төлөөлөлгүй байна. Иймд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх



чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Сонгуулийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байхаар тогтоосон болно.

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Улсын Их Хурал нь “... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;” асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2019 оны 22 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд улс төрийн нам сонгуульд оролцохтой холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, мөн зүйлийн 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэж тус тус заасан. Энэ зохицуулалт нь нам сонгуульд оролцохоос өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тодорхой хугацааг заасан шалгуурыг анх удаа тогтоосон асуудал биш бөгөөд өмнө нь үйлчилж байсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиудад Улсын Их Хурлын сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар зохицуулж байсан. ...

Венецийн комиссын 2010 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Улс төрийн намын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад удирдлага болгох зарчмууд”-ыг хэлэлцэн баталсан бөгөөд энэ баримт бичигт улс төрийн нам гэдэг нь чөлөөт, ардчилсан сонгуульд нэр дэвшүүлэх, төрийн үйл хэргийг удирдахад оролцох замаар иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлэхийг нэг зорилтоо болгосон иргэдийн сайн дурын нэгдэл мөн гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, эсхүл өөрийн гишүүдийг төрийн эрх барих байгууллагад сонгуульд оролцуулах замаар улс төрийн салбарт

засаглах бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг зорьсон иргэдийн сайн дурын аливаа нэгдэлд хамаарна гэсэн байна. Мөнхүү баримт бичигт дурдсанаар улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.

Төрийн үйл хэргийг удирдахад оролцох, төрийн бодлогыг тодорхойлох, улмаар зарим давуу байдлыг олж авдгийн хувьд улс төрийн нам төрийн сонгуульд оролцох хүсэлтээ илэрхийлэх нь санамсаргүй, гэнэтийн, тохиолдлын зүйл байх ёсгүй буюу зөвхөн тухайн нэг сонгуульд аливаа зорилгоор оролцохын тулд улс төрийн намыг хэлбэрийн төдий байгуулах, дотооддоо бэхжиж, үйл ажиллагаа нь тогтворжоогүй, бодлого, үзэл баримтлалаа тодорхойлоогүй улс төрийн намыг төрийн сонгуульд оролцуулах нь өөрөө сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй гэж үздэг.

Эдгээр үндэслэлүүдээр Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэгт тавьсан шаардлага нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...” гэж тус тус заасныг баталгаажуулан бэхжүүлсэн, иргэдийн эрхийг баталгаатай хангах нөхцөлийг хамгаалсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” 49 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ... –ыг хориглоно.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх



хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.” гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 02 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэх хэсгийн “Хоёр”-т:

“... 2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуульд нэр дэвшүүлэх эрхийн талаарх зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсэгт “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэжээ. Түүнчлэн, тус хуулийн 124 дүгээр зүйлийн 124.3.1 дэх заалтад “санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй;” бол нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэхээс татгалзахаар нийтлэг байдлаар зохицуулсан байна.

Гэтэл Улс төрийн намын тухай хуульд зааснаар 801 ба түүнээс олон иргэн сайн дураараа нэгдэж нам байгуулан, хөтөлбөр, дүрмээ баталж, Улсын дээд шүүхэд хянуулж бүртгүүлснээр гэрчилгээ авч үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн зохицуулалт нь 180-аас доош хоногийн өмнө нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд хуульд зааснаар сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн улс төрийн нам дангаараа болон бусад нам, улс төрийн хүчинтэй эвсэж уг сонгуульд оролцох, нэр дэвшүүлэх боломжгүй болгожээ. Өөрөөр хэлбэл, тухайн намын гишүүд, дэмжигч иргэд төрийн байгууллагад сонгогдох, сонгох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч Сонгуулийн тухай

хуулиар бүрэн бүрдүүлээгүй буюу Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэн Б.Ууганбаярын мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг бий болгосон байна.

Ингэснээр хугацааны шалгуураар иргэд аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө буюу гишүүнийхээ хувьд ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болж, улмаар тэдний хувьд тэгш бус байдлыг үүсгэжээ.

Үүний зэрэгцээ Сонгуулийн тухай хуулийн дээрх заалтууд нь зөвхөн Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн хүрээнд төдийгүй Улсын Их Хурлын бусад аль ч төрлийн сонгуульд улс төрийн нам оролцоход хугацаанаас хамаарч ялгавартай байдлаар хандах боломжийг бүрдүүлсэн нь иргэдийн улс төрийн эрхийг хөндсөн, ардчилсан ёсны зарчмыг алдагдуулсан байна. Тодруулбал, сонгуульд оролцох улс төрийн намд тодорхой шалгуурыг хуулийн хүрээнд тогтоож болох боловч уг шалгуур нь үндэслэлтэй бөгөөд хариуцлага, санхүүжилт, илт тод байдал гэх зэрэг хуулийн бусад зохицуулалттай уялдсан, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцсэн байх учиртай юм. Гэтэл дээрх заалтуудад тусгасан “180-аас доошгүй хоног”-ийн хугацааны шалгуур нь эдгээрт хамаарахгүй байна. Улсын Их Хурлаас ирүүлсэн хариу тайлбарт “улс төрийн намыг бүртгүүлэхэд зарим нэг шаардлага тавих нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдэд заасан байна.” гэсэн боловч нотолгоог тодорхой дурдаагүй байна. Мөн өнөөдрийн хэлэлцэж буй маргаан нь улс төрийн намыг бүртгэх тухай бус нэгэнт бүртгэгдсэн намыг сонгуульд оролцохтой холбоотой асуудал байгаа болно. Харин Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалж, баталгаажуулсан шийдвэрүүд зонхилж байх ба эдгээр нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 22 болон Хүний эрхийн тухай Европын конвенцийн 11 дүгээр зүйлийг үндэслэж, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг зөвхөн үндэсний болон нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаар хязгаарлалт тавьж болно; үүнээс өөр хязгаарлалтыг зөвхөн гарцаагүй бөгөөд үндэслэлтэй учир шалтгаан байгаа тохиолдолд хэрэглэнэ; уг хязгаарлалт нь тавьж буй хууль ёсны зорилгод дүйцэхүйц байхаас гадна нөхцөл байдалд нийцсэн, энэ талаарх нотолгоотой байх хэрэгтэй талаар тусгасан байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн түүхчилсэн судалгаанаас үзэхэд өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулиудад улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцох тохиолдолд ийнхүү тухайлан хагас жилээс доошгүй хугацааны өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх тухай зохицуулалтыг тусгаагүй байх ба 1992 оны Монгол Улсын Их Хурлын



сонгуулийн тухай хуульд “Нам сонгуульд оролцохоо санал авах өдрөөс 65 хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ. 2005, 2011 оны хуульд сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй байхаар заасан байсныг дурдах нь зүйтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гаргасан дүгнэлт, мөн оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гаргасан 03 дугаар тогтоолдоо “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй” гэж, “сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй” гэж, мөн “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонгогч, сонгогдогч иргэдийн эрхийг тэгш хангаж холбогдох заалтыг өөрчлөх эрх нь хууль тогтоогчид байгаа” талаар тус тус тухайлан тусгаж Улсын Их Хуралд уламжилж байсан болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээж байгаа юм.

Гэтэл Монгол Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох улс төрийн намын тэгш байдлыг хангах ёстой атал тэгш бус байдлыг бий болгосон, сонгогч, сонгогдогч иргэдэд үндэслэлгүй ялгаварлал бий болгосон сонгуулийн хуулийн хийдэл, дутагдлыг арилгахгүйгээр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрог нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Дээр дурдсан үндэслэл, нөхцөл байдлаас үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрог нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг

иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчигдөх нөхцөл бүрдүүлсэн байна.

4. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт “Ээлжит сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтооно.” гэж хуульчилжээ. Харин тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” хэмээн заасан боловч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг зарлах шийдвэрийг хэзээ гаргах талаар уг хуульд тусгайлан хуульчлаагүй байна. Гэтэл сонгуулийн эрх зүй нь Үндсэн хуулийн эрх зүйн бусад институттэй харьцуулахад процессын хэм хэмжээ ихээр агуулдаг онцлогтой бөгөөд сонгуулийн үйл явцын үе шат бүрийн эхлэх, дуусгавар болох хугацааг нарийвчлан тогтоосон байхыг шаарддаг. Ийнхүү тогтоогоогүй тохиолдолд нийтийн эрх зүйн зарчмын дагуу ерөнхий зохицуулалтыг удирдлага болгох учиртай. Иймд уг зарчмын хүрээнд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах өдрийг санал авах өдрөөс 150-иас доошгүй хоногийн өмнө тогтоохоор байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурал нь Сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан зохицуулалтыг зөрчиж, 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр 22 дугаар тогтоол гарган 148 хоногийн өмнө Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийн санал авах өдрийг тогтоосон байна. Ийнхүү Улсын Их Хурлын 2019 оны 22 дугаар тогтоол нь холбогдох хуулийн заалтад үл нийцсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

5. Монгол Улсын Их Хурал 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарласан бөгөөд үүнтэй уялдуулан мөн өдрийн 23 дугаар тогтоолоороо тус сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардлын хэмжээг тогтоож, уг зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.



Харин Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.14 дэх заалтад Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилжээ. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан...” гэж тодорхойлоод, тус хуулийн 8 дугаар зүйлд “Засгийн газрын нөөц сан”-аас төсөв батлахаас өмнө урьдчилан харах боломжгүй тодорхой хэдэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр зохицуулжээ. Харин Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж заасан ба мөн Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуультай холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гарсан зэргээс үзэхэд уг нөхөн сонгуулийг 2019 онд явуулах нь тодорхой байсан юм. Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь дээрх хуулиудын зохицуулалтад үл нийцжээ. Улмаар Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна. ...” гээд Тогтоох хэсэгт “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага,

иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг; мөн өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна.” гэж дүгнэн, 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” 66 дугаар тогтоолд:

“1. “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. “Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх



зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Я.Санжмятав нар Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“... Сонгуулийн тухай хуулийн 16.3-т заасны дагуу санал авах өдрийг тогтоох тухай 150 хоног нь ээлжит сонгуульд хамаарах бөгөөд хэзээ, ямар нөхөн сонгууль болох нь урьдчилан тооцох боломжгүй тул энэхүү хугацаа нь нөхөн сонгуулийн санал авах өдрийг товлон зарлахад хамаарахгүй юм.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн ньТөсвийн тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу Засгийн газрын нөөц сан нь 100 хувь эх үүсвэрийг нь төсвийн хөрөнгөөр бүрдүүлдэг сангийн ангилалд хамаардаг бөгөөд уг сангаас төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлж байхаар хуульчилсан тул нөхөн сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах нь хууль зөрчөөгүй болно

Иймд Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоол тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.” мөн зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс

нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно.” Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...”, Далдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсэг “...Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг; мөн өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасгай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам Улсын Их Хурлын сонгуульд оролцож, нэр дэвшүүлэх эрхтэй.”, 12.3 дахь хэсгийн “Эвсэлд нэгдсэн бүх нам санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангасан байна.” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.” гээд мөн зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...”, мөн зүйлийн 10 дахь заалтад “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах ...-ыг хориглоно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн тул хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн



газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

4.“Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

5.Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Н.ЧИНБАТ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Ш.СОЛОНГО
Г.ТУУЛХҮ
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН**

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Хавсралт

**УЛААНБААТАР ХОТНОО 2017 ОНЫ 5 ДУГААР САРЫН 9-НИЙ
ӨДӨР БАЙГУУЛСАН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ
ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, цаашид “Хэлэлцэн тохиролцогч талууд” гэх, Монгол Улс болон Польш Улс хоорондын эдийн засгийн үр дүнтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 13 дугаар зүйлийн дагуу дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулав.

- 1) 1 дүгээр зүйлийг “Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар Монгол Улсын хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсролын шинэчлэл, байгаль орчин хамгаалал болон эрүүл мэндийн үйлчилгээний салбарын төслийн санхүүжилтэд зориулан 50 сая (тавин сая) хүртэлх еврогийн зээлийг (цаашид “зээл” гэх) Монгол Улсын Засгийн газарт олгоно. Энэхүү зээлийг Бүгд Найрамдах Польш Улсад Монгол Улсад нийлүүлэх бараа, үйлчилгээний гэрээний үнийн дүнг 100% (зуун хувь) санхүүжүүлэхэд ашиглана. “Хавсралтад зээлийн хүрээнд санхүүжүүлэх төслийг тодорхой тусгах бөгөөд энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.” гэж өөрчлөх.
- 2) 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан гэрээг Монгол Улсын импортлогч болон Бүгд Найрамдах Польш Улсад байршилтай үйлдвэрлэгч (цаашид “Польшийн үйлдвэрлэгч” гэх) нарын хооронд 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрөөс өмнө байгуулна.” гэж өөрчлөх.
- 3) Зээлийн хүрээнд санхүүжүүлэх төслийг тодорхойлсон хавсралт гэх нэр, томъёоллыг энэхүү хавсралтад нэмнэ.

2 дугаар зүйл

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Хэлэлцэн тохиролцогч тал тус бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу батлагдах бөгөөд энэ тухайгаа ноот бичиг солилцон баталгаажуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болно.

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралт нь Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч хоёр талын хүлээсэн бүх үүрэг биелэгдэх хүртэл хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.



Улаанбаатар хотноо 2019 оны 7 сарын 9-ний өдөр монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Эх бичвэрүүдийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эхийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Хавсралт

Энэхүү хавсралтын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсан Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу санхүүжүүлэх төсөл:

1. Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих
 - 1.1 Баян-Өлгий аймгийн Өлгий сум
 - 1.2 Говьсүмбэр аймгийн Чойр сум
 - 1.3 Дорнод аймгийн Чойбалсан сум
 - 1.4 Увс аймгийн Улаангом сум
 - 1.5 Завхан аймгийн Улиастай сум
2. Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх
3. Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн хөдөлгөөнт II шатлалын эмнэлэг
4. Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх
5. Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах
6. Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин ханган нийлүүлэх



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ GERMAN УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР 2016-2017 ОН

GERMAN-МОНГОЛЫН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Монгол Улсын Засгийн газар,

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар,

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд
тогтсон найрсаг харилцааны үзэл санаанд тулгуурлан,

энэхүү найрсаг харилцааг түншилсэн Санхүүгийн хамтын
ажиллагаагаар бэхжүүлэн, гүнзгийрүүлэхийг эрмэлзэж,

уг харилцааг хэвээр хадгалах нь энэхүү хэлэлцээрийн үндсийг
бүрдүүлнэ гэдгийг ухамсарлан,

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд байгаль орчны
тогтвортой байдалд тулгуурлан хувь нэмэр оруулах зорилгоор,

хоёр орны Засгийн газар хоорондын 2016 оны 11 дүгээр сарын 25-
ны өдрийн хэлэлцээрийн протоколыг үндэслэн

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл

(1) Хэрэв дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж судалгааны дүнд тогтоовол
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар нь Монгол
Улсын Засгийн газарт “Герман-Монголын Ашигт малтмал, технологийн их
сургууль” төсөлд 7 000 000 (үсгээр: долоон сая) хүртэлх еврогийн зээлийг
Сэргээн босголтын зээлийн банк (KfW)-наас авах боломж олгоно.

(2) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар,
Монгол Улсын Засгийн газар харилцан тохиролцсоноор 1 дэх хэсэгт
дурдсан төслийг өөр төслүүдээр орлуулж болно.

(3) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар нь
1 дэх хэсэгт дурдсан төслийн бэлтгэл ажлыг хангахад зориулан нэмэлт

зээл, эсхүл санхүүгийн тусламж, эсхүл 1 дэх хэсэгт дурдсан төслийг хэрэгжүүлэх, дэмжихэд шаардагдах дагалдах арга хэмжээнд зориулан нэмэлт санхүүгийн тусламж Сэргээн босголтын зээлийн банкнаас авах боломжийг Монгол Улсын Засгийн газарт хожим олгох тохиолдолд энэхүү хэлэлцээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

2 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хөрөнгийг ашиглах, олгох нөхцөл болон ажил гүйцэтгүүлэх журам зэргийг Сэргээн босголтын зээлийн банк, зээл хүлээн авагчийн хооронд байгуулах, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад мөрдөж буй хууль тогтоомжийг мөрдлөг болгох гэрээгээр зохицуулна.

(2) Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хөрөнгийг олгох амлалт өгснөөс хойш зургаан жилийн дотор холбогдох зээлийн гэрээнүүд байгуулагдаагүй тохиолдолд уг амлалт хүчингүй болно. Дээрх хэсэгт дурдсан хөрөнгийн хувьд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр уг хугацаа дуусгавар болно.

(3) Монгол Улсын Засгийн газар нь зээл хүлээн авагч биш байх тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу байгуулах гэрээг үндэслэн зээл хүлээн авагчийн бүх төлбөрийг еврогоор буцаан төлөх баталгааг Сэргээн босголтын зээлийн банкинд гаргана.

3 дугаар зүйл

Монгол Улсын Засгийн газар нь энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэрээнүүдийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдон ноогдуулж болох Монгол Улсын шууд татвараас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө. Дээр дурдсантай холбогдуулан ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад адил төрлийн шууд бус татвар, ногдуулсан онцгой албан татварыг Монгол Улсын Засгийн газар хариуцна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар нь бусад албан хураамжаас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө.

4 дүгээр зүйл

Монгол Улсын Засгийн газар нь зээл олгосонтой холбоотойгоор зорчигч болон ханган нийлүүлэгчдийг хуурай болон усан зам, агаараар хүн болон бараа тээвэрлэх тээврийн байгууллагыг чөлөөтэй сонгох боломжоор ханган, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад байрладаг тээврийн байгууллагуудыг үүнд тэгш эрхтэй оролцоход саад тотгор болох, эсхүл хязгаарлах аливаа арга хэмжээг авахаас түдгэлзэн, шаардлагатай нөхцөлд тэдэнд зохих зөвшөөрлийг олгоно.

5 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай мэдэгдлийг Монгол Улсын Засгийн газраас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газарт хүргүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох өдөр нь дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдөр байна.

(2) Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болмогц Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар бүртгэж авснаа баталгаажуулмагц Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд хэлэлцээрийг бүртгүүлсэн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүртгэлийн дугаарыг мэдээлнэ.

(3) Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тохиролцож болно.

(4) Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талууд яриа, хэлэлцээний замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Улаанбаатар хотноо 2019 оны 6 сарын 26-ны өдөр монгол, герман, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр нь адил хүчинтэй. Монгол, герман хэлээрх эх бичвэрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
GERMAN УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ САНГИЙН ЯАМ
("Зээлдэгч"),

болон

ФРАНКФУРТ ХОТ ДАХЬ СЭРГЭЭН БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН БАНК
("СБЗБ"),

хоорондын

2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн

7,000,000.00 ЕВРОГИЙН

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

"Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль"
BMZ-№.2016 65 017

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагаа хэлэлцээр ("Засгийн газар хоорондын хэлэлцээр")-ийг үндэслэн Зээлдэгч болон Сэргээн босголт зээлийн банк (СБЗБ)-ны хооронд дараах Зээлийн болон төслийн гэрээг байгуулав:

Нэгдүгээр зүйл - Зээлийн хэмжээ ба зориулалт

1.1. СБЗБ нь Зээлдэгчид дараах мөнгөн дүнгээс илүүгүй хэмжээний зээл олгоно.

7,000,000.00 евро
("Зээл")

1.2. Зээлдэгч нь зээлийг зөвхөн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт байрлах Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль ("АМТИС")-ийн тоног, төхөөрөмжийг орчин үеийн тоног төхөөрөмж болгох, барилгын бүтээн байгуулалт түүний дэд бүтцийн өргөжилт болон тус барилга байгууламжийн тогтвортой ажиллагааг хангуулах үүднээс АМТИС-ийн багш, ажилчдыг сургах болон гадаад валютын зардлын төлбөрт голчилж хэрэглэнэ.

Зээлдэгч буюу энэ тохиолдолд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам ("БСШУСЯ") болон СБЗБ нь Төслийг нарийвчлан тодорхойлж, зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг тусгайлсан гэрээгээр тохиролцоно.



1.3. Зээлдэгчийн хариуцах аливаа татвар, бусад хураамж ба импортын татварыг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

Хоёрдугаар зүйл - Зээлийн санхүүжилт олгох

2.1. СБЗБ нь төслийн явц болон Зээлдэгчийн зээлийн хүсэлтийн дагуу зээлийн санхүүжилтийг олгоно. Зээлдэгч (энэ тохиолдолд БСШУСЯ) болон СБЗБ хоорондын Тусгайлсан гэрээгээр зээлийн санхүүжилт олгох журам, ялангуяа хүсэлт гаргасан зээлийн дүнг тохиролцсон зориулалтад ашиглагдсаныг нотлох баримт бүрдүүлэх талаар тохиролцоно.

2.2. СБЗБ нь 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хойш зээлийн санхүүжилт олгохоос татгалзах эрхтэй.

Гуравдугаар зүйл- Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү, эргэн төлөлт

3.1. Зээлдэгч нь ашиглагдаагүй зээлийн хэмжээнд жилийн 0,25 хувийн хүү хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжид төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг энэхүү зээлийн гэрээнд гарын үсэг зурснаас хойш гурван сарын дараагаас эхлэн тооцох ба зээлийг бүрэн олгосон өдрөөр дуусгавар болно.

3.2. Зээлдэгч нь жилийн 2 хувийн зээлийн хүү төлнө. Хүүг зээлийн хөрөнгийн санхүүжилт эхэлсэн өдрөөс эхлэн тооцож, энэхүү зүйлийн 3.9-д заасан СБЗБ-ны дансанд эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд бодож төлнө.

3.3. Зээлдэгч нь хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү зүйлийн 3.5-д заасан хугацаа хэтэрсний аливаа хураамжийг хагас жил тутам, жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдөр, 12 дугаар сарын 30-ны өдөр төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны эхний хураамжийг анхны хүүгийн төлбөртэй хамт төлнө.

3.4. Зээлдэгч нь зээлийг дараах байдлаар эргүүлэн төлнө.

Төлөлт хийх хуваарь	Сар, өдөр	Жил	Хэмжээ /Евро/
1	12-р сарын 30	2029	175,000.00
2	6-р сарын 30	2030	175,000.00
3	12-р сарын 30	2030	175,000.00
4	6-р сарын 30	2031	175,000.00
5	12-р сарын 30	2031	175,000.00
6	6-р сарын 30	2032	175,000.00



7	12-р сарын 30	2032	175,000.00
8	6-р сарын 30	2033	175,000.00
9	12-р сарын 30	2033	175,000.00
10	6-р сарын 30	2034	175,000.00
11	12-р сарын 30	2034	175,000.00
12	6-р сарын 30	2035	175,000.00
13	12-р сарын 30	2035	175,000.00
14	6-р сарын 30	2036	175,000.00
15	12-р сарын 30	2036	175,000.00
16	6-р сарын 30	2037	175,000.00
17	12-р сарын 30	2037	175,000.00
18	6-р сарын 30	2038	175,000.00
19	12-р сарын 30	2038	175,000.00
20	6-р сарын 30	2039	175,000.00
21	12-р сарын 30	2039	175,000.00
22	6-р сарын 30	2040	175,000.00
23	12-р сарын 30	2040	175,000.00
24	6-р сарын 30	2041	175,000.00
25	12-р сарын 30	2041	175,000.00
26	6-р сарын 30	2042	175,000.00
27	12-р сарын 30	2042	175,000.00
28	6-р сарын 30	2043	175,000.00
29	12-р сарын 30	2043	175,000.00
30	6-р сарын 30	2044	175,000.00
31	12-р сарын 30	2044	175,000.00
32	6-р сарын 30	2045	175,000.00
33	12-р сарын 30	2045	175,000.00
34	6-р сарын 30	2046	175,000.00
35	12-р сарын 30	2046	175,000.00
36	6-р сарын 30	2047	175,000.00
37	12-р сарын 30	2047	175,000.00
38	6-р сарын 30	2048	175,000.00
39	12-р сарын 30	2048	175,000.00
40	6-р сарын 30	2049	175,000.00
	Нийт		7,000,000.00

3.5. Зээлийн эргэн төлөлт хуваарьт хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд уг төлбөрийг энэхүү зүйлийн 3.9-д заасан СБЗБ-ны дансанд төлөгдөх хүртэл СБЗБ нь хугацаа хэтэрсэн төлбөрийн хэмжээнд жилийн суурь хүүг 3 хүртэлх хувиар нэмэгдүүлж бодох эрхтэй. “Суурь хүү” гэдэг нь төлбөр төлөгдөх ёстой байсан өдрийн Германы Холбооны банкнаас тогтоосон хүүг хэлнэ. Зээлийн хүүг төлөх хугацаа хэтэрсэн тохиолдолд



СБЗБ нь учирсан хохирлыг барагдуулахыг шаардах эрхтэй. Уг хохирлын хэмжээ нь суурь хүү дээр жилийн 3 хувиар нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээнээс хэтрэхгүй байна.

3.6. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, зээлийн хүү болон энэхүү зүйлийн 3.5-д заасан хугацаа хэтэрсэн төлбөрийн торгуулийг жилийн 360 хоногоор, сарын 30 хоногоор үндэслэн тооцно.

3.7. Ашиглагдаагүй болон хугацаанаас өмнө төлсөн зээлийг шилжүүлэхдээ эргэн төлөх хуваарийн дагуу үлдсэн төлбөрт тэнцүү хэмжээгээр ногдуулах бөгөөд СБЗБ нь тодорхой нөхцөлд, тухайлбал төлбөрийн хэмжээ нь бага байвал өөр тусгай аргаар бие дааж тодорхойлно.

3.8. СБЗБ, Зээлдэгчийн хооронд байгуулсан бусад зээлийн хэлэлцээр болон энэхүү хэлэлцээрийн дагуу эргэн төлсөн зээлийн хөрөнгийг дахин зээлд ашиглах асуудлыг СБЗБ бие даан шийдвэрлэх эрхтэй.

3.9. Зээлдэгч нь аливаа төлбөрийг доорх данс хаягаар, Еврогоор шилжүүлэх бөгөөд энэхүү төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхгүй.

Хүлээн авагч: СБЗБ (KFW)

SWIFT-BIC:

KFWIDEFF

IBAN:

DE94 5002 0400 3139 4059 82

**Дөрөвдүгээр зүйл- Зээлийн санхүүжилтийг зогсоох,
хугацаанаас өмнө төлбөр хийх**

4.1. Зээлдэгч ямар ч үед:

а) энэхүү гэрээний 7 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ашиглагдаагүй байгаа зээлийн хөрөнгийг хэмжээ харгалзахгүй цуцлах,

б) зээлийг хугацаанаас нь өмнө бүхэлд нь эсвэл хэсэгчлэн эргүүлэн төлж болно.

4.2. СБЗБ нь доор дурдсанаас бусад тохиолдолд зээлийн ашиглалтыг цуцлах эрхгүй:

а) Зээлдэгч нь зээлийн төлбөрийг хугацаанд нь СБЗБ-нд төлөх үүргээ биелүүлээгүй бол,



б) Энэхүү гэрээ болон тусгайлсан гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол,

с) Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан гэдгээ нотолж чадахгүй байх,

д) Энэхүү гэрээний дагуу СБЗБ-ийн үүргийг биелүүлэх нь холбогдох хуулийг зөрчсөн бол,

е) төслийн зорилго, түүний хэрэгжүүлэлт, үйл ажиллагаанд эсхүл Зээлдэгчийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу төлбөр хийхэд давтагдашгүй хүчин зүйлийн улмаас боломжгүй болох буюу ноцтой саад тотгор учирсан тохиолдолд.

4.3. Энэхүү зүйлийн 4.2-ын а), б), с) эсвэл d) хэсгүүдэд дурдсан нөхцөл байдал бий болсон тохиолдолд СБЗБ-наас тогтоосон 30 хоногоос багагүй хугацаанд асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд СБЗБ нь дараах эрхтэй:

а) Энэхүү зүйлийн 4.2-ын а), 4.2 б) эсвэл 4.2 d)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд зээлийн нийт үлдэгдэл, хуримтлагдсан нийт хүү болон бусад холбогдох бүх төлбөрийг нэн даруй буцааж төлөхийг шаардах,

б) Энэхүү зүйлийн 4.2-ын с)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд, Зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашигласан гэдгийг нотолж чадаагүй бол тухайн хэмжээний зээлийг нэн даруй буцааж төлөхийг шаардах.

Тавдугаар зүйл-Зардал ба хураамж

5.1. Зээлдэгч нь энэхүү гэрээний дагуу хийх бүх төлбөрийг татвар, бусад хураамж, суутгалгүйгээр шилжүүлэх бөгөөд зээлийн хөрөнгийг шилжүүлэхтэй холбогдон гарсан зардал болон ханшийн зөрүүг төлнө.

5.2. Зээлдэгч нь ХБНГУ-ын нутаг дэвсгэрийн гадна энэхүү хэлэлцээрийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа татвар, улсын хураамжийг хариуцна.

Зургаадугаар зүйл-Хэлэлцээр хүчин төгөлдөр болох болон төлөөлөх

6.1. Зээлдэгч нь анхны зээлийн санхүүжилт хийгдэхээс өмнө энэхүү Хэлэлцээрээр хүлээх үүргээ биелүүлэхэд шаардлагатай өөрийн



улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтуудыг бүрэн хангаж буйгаа нотолсон, СБЗБ-ны шаардлагыг хангахуйц баримтыг СБЗБ-нд хүргүүлнэ.

6.2. Монгол Улсын Сангийн сайд болон түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон, баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Зээлдэгчийг төлөөлнө. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сайд болон түүний СБЗБ-нд итгэмжлэн томилсон баталгаат гарын үсэг бүхий этгээд энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд Зээлдэгчийг төлөөлнө. Төлөөлөгч этгээдийн томилолтыг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг СБЗБ хүлээж авах хүртэл төлөөллийн бүрэн эрх хүчин төгөлдөр байна.

6.3. Энэхүү гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт болон гэрээтэй холбогдолтой бусад мэдэгдэл, тайлбарыг оролцогч талууд бие биедээ бичгээр хүргүүлнэ. Оролцогч талууд доорх хаягаар, эсхүл нөгөө талдаа мэдэгдсэн бусад хаягаар дээрх мэдэгдлийг хүлээн авснаар мэдэгдсэнд тооцно.

СБЗБ: KfW
Postfach 11 11 41
60046 Frankfurt am Main
Federal Republic of Germany
Fax: +49 69 7431-2944

Зээлдэгч: Сангийн яам,
Нэгдсэн үндэстний гудамж-5/1
Улаанбаатар хот 15160,
Монгол улс
Факс: +976 51 262171

Төсөл хэрэгжүүлэгч
байгууллага: Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан,
Спортын яам
14200, Бага тойруу 44, ЗГ-ын 3-р байр
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
Монгол улс
Факс: +976 11 323 158

Долоодугаар зүйл - Төсөл

7.1. Зээлдэгч

а) Хүрээлэн буй орчны болон нийгмийн стандартад нийцүүлэн Зээлдэгч болон СБЗБ хооронд тохирсны дагуу Төслийг хэрэгжүүлэх



төлөвлөгөө болон санхүү, инженерийн туршлагад нийцүүлэн Төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, түүний хэвийн ажиллагааг хангах үүрэгтэй.

b) Төслийн хүрээнд хийгдэх барилгын ажилд бэлтгэх болон хяналт тавихад бие даасан, мэргэшсэн зөвлөхийг, мөн төсөл хэрэгжилтэд мэргэшсэн байгууллагыг тус тус томилно,

c) Урьдчилан явуулсан олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үндсэн дээр бараа, ажил, үйлчилгээ Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэрээг байгуулна.

d) Төслийн санхүүжилтийг ханган Төслийн бүх санхүүжилтийг баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд СБЗБ-ны хүсэлтээр зээлийн хөрөнгөөр санхүүжигдээгүй бусад зардлыг шийдвэрлэсэн гэсэн нотлох баримтыг гаргаж өгнө,

e) СБЗБ хүссэний дагуу Төсөлд шаардлагатай бүх бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн тодорхой жагсаалтыг гаргаж, эдгээр төлбөр нь Зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн гэдгийг нотлох тайлан, мэдээлэл бүхий санхүүгийн баримт бичгийг хөтлөх үүргийг хүлээнэ.

f) СБЗБ-ны төлөөлөгчдөд Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой дээр дурдсан бүртгэл, тайлан болон бусад баримт бичгүүдийг шалгах, Төслийн хэрэгжилт, холбогдох байгууламжуудтай газар дээр нь танилцах нөхцөлөөр хангана.

g) СБЗБ-ны хүсэлтийн дагуу Төслийн арга хэмжээг хэрэгжүүлэх болон түүний цаашдын үйл явцтай холбоотой бүх мэдээ, тайланг СБЗБ-нд гаргаж өгнө.

h) Төслийн зорилт, үйл ажиллагаа, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, ноцтой саад учруулах аливаа нөхцөл байдлын талаар СБЗБ-нд нэн даруй мэдэгдэнэ.

i) Зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний талаар “Хөгжлийн албан ёсны тусламжийн зээлийн ил тод байдлын хэлэлцээр”-ийн дагуу Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага эсхүл түүний гишүүдийн зүгээс Зээлдэгчид тавьсан аливаа асуулгыг хугацаа алдалгүй СБЗБ-нд дамжуулах бөгөөд асуулгын хариуг СБЗБ-тай зөвшилцөнө.

j) АМТИС-ийн өргөтгөсөн хотхоны үйл ажиллагааг СБЗБ-ны шаардлагыг хангасан түвшинд тогтвортой, урт хугацаанд санхүүжүүлэх



талаар хүчин чармайлт гаргах, СБЗБ-ны хүсэлтээр нотолгоог шаардлагатай хэмжээнд гаргаж өгөх;

к) АМТИС-ийн өргөтгөсөн хотхоны үйл ажиллагааны төсөв Монгол Улсын төсөвт тусгагдах талаар нотолгоог СБЗБ-д дараах дарааллаар гаргаж хүргүүлнэ. и) Зээлээр санхүүжих бараа материал худалдан авах, үйлчилгээ үзүүлэх тендер зарлагдахаас өмнө 2022 онд буюу эхний жилийн үйл ажиллагааны зардал төсөвт тусгагдах тухай ii) 2023-2025 оны төсөвт тусгагдах тухай, түүнээс цааш жил тутам.

7.2. БСШУСЯ болон СБЗБ нь энэ зүйлийн 7.1-д заасан асуудлуудыг тусгай хэлэлцээрээр нарийвчлан зохицуулна.

7.3. Энэхүү Зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, материалыг тээвэрлэхэд Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нөхцөлүүд хэрэглэгдэнэ.

Наймдугаар зүйл - Төсөлтэй холбогдолтой мэдээллийг нийтлэх болон шилжүүлэх

8.1 Төсөлтэй холбоотой гэрээг хэрэгжүүлж байх үед болон дараах үе шатанд (цаашид «Бүхий л цаг үе» гэх) хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд ил тод байдал, үр ашгийн талаарх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг дагаж мөрдөх бөгөөд СБЗБ нь Төслийн талаар (үнэлгээний тайлангийн хамт) болон гэрээний өмнөх хэлэлцээрийн үеэр хэрхэн санхүүжих талаар зарим сонгогдсон мэдээлэл гаргах.

Мэдээлэл нь СБЗБ-ны «KfW Development Bank» (<http://transparenz.kfw-entwicklungsbank.de/>) бизнесийн вэбсайт дээр тогтмол нийтлэгдэнэ.

Нийтлэх мэдээлэлд (СБЗБ эсвэл гуравдагч этгээд нь доорх 8.3-р зүйлийн дагуу) Төслийн талаар болон хэрхэн санхүүжиж байгаа тухай байх бөгөөд харин гэрээний баримт бичиг эсвэл Төсөлд оролцсон талуудын талаарх санхүүгийн болон бизнесийн холбогдолтой нарийвчилсан мэдээлэл зэргийг агуулаагүй байна. Тухайлбал:

- a. Санхүүгийн дотоод мэдээллийн талаар;
- b. Бизнесийн стратеги;
- c. Компанийн дотоод удирдамж, тайлан;
- d. Хүмүүсийн хувийн мэдээлэл;
- e. Талуудын санхүүгийн байдлын талаарх СБЗБ-ны дотоод үнэлгээ.

8.2 СБЗБ нь төслийн үйл ажиллагаа хэрхэн санхүүжиж байгаа талаарх зарим мэдээллийг төсөл хэрэгжих бүхий л цаг үед дор дурдсан байгууллагуудад ил тод, үр ашигтай байдлыг хангахын тулд хуваалцана.

а) СБЗБ-ны салбарууд;

б) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон түүний эрх бүхий байгууллага, институт, агентлаг аль эсвэл аж ахуй нэгж;

в) Германы хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр ажилладаг бусад хэрэгжүүлэгч байгууллагууд, ялангуяа Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (Deutsche Gesellschaft Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH);

д) Статистикийн мэдээг цуглуулах олон улсын байгууллага түүний гишүүд ялангуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) болон түүний гишүүд.

8.3 Түүнчлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тавьсан хүсэлтийн дагуу СБЗБ нь төслийн талаар болон хэрхэн санхүүжиж байгаа талаарх мэдээллийг төсөл хэрэгжих бүхий л цаг үед дараах нэгжүүдэд (энэ төслийн зорилгод хамаарах нэгжүүдэд мэдээлэх).

а) Олон улсын тусламжийн ил тод байдлын санаачлагын зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (http://www.bmz.de/de/was_wir_machen/wege/transparenz-fuer-mehr-Wirksamkeit/index.html);

б) Герман Худалдаа ба Хөрөнгө оруулалт (GTAI) зах зээлийн мэдээллийн зорилгоор (<http://www.gtai.de/GTAI/Navigation/DE/trade.FOO>);

в) Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн урсгалыг тайлагнах зорилгоор ЭЗХАХБ (<http://stats.oecd.org/>);

д) Германы Хөгжлийн Үнэлгээний Хүрээлэн (DEVal) нь Германы ерөнхий хөгжлийн хамтын ажиллагааг үнэлэх зорилгоор ил тод, үр ашигтай байдлыг хангах (<http://www.deval.org/de/>).

8.4 Төслийн талаар болон хэрхэн санхүүжиж буй талаарх мэдээллийг төслийн бүхий л цаг үед хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд бусад гуравдагч этгээдэд СБЗБ цаашид шилжүүлэх эрхтэй (үүнд хэвлэн нийтлэх зорилгоор).

СБЗБ нь гуравдагч этгээдэд нэмэлт мэдээлэл дамжуулах сонирхолтой боловч Зээлдэгч тус мэдээллийг гуравдагч этгээдэд



нийтлэхгүй гэсэн хууль ёсны ашиг сонирхолтой байвал СБЗБ нь мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй. Зээлдэгчийн хууль ёсны ашиг сонирхол гэдэг 8.1-д дурдсан нууцлалтай, эмзэг мэдээлэл ялангуяа хамаарах бөгөөд эдгээр мэдээллийг нийтлэхгүй.

Цаашилбал, СБЗБ нь хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагууд, шүүхийн болон захиргааны журмаар нэхэмжлэлийн болон шүүхийн бусад эрхүүдийг баталгаажуулах буюу хамгаалах үүднээс шаардлагатай бол гуравдагч этгээдэд мэдээллийг шилжүүлэх эрхтэй.

Есдүгээр зүйл - Бусад зүйл

9.1. Зээлдэгч нь бүхий л цаг үед Хавсралтад заасан (Хэрэгжилтийг хангах нөхцөл) үүрэг хариуцлагыг мөрдлөг болгоно.

9.2 Энэхүү гэрээний аль нэг заалт хүчингүй болох тохиолдолд бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Хүчингүй болсон заалтыг гэрээний зорилгод нийцсэн өөр заалтаар орлуулна.

9.3 Зээлдэгч болон Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү гэрээгээр хүлээсэн аливаа эрхээ бусдад шилжүүлэх, дэнчин барьцаа болгож болохгүй.

9.4 Энэхүү гэрээний хүрээнд СБЗБ нь шаардах эрх үүссэнийг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан тохиолдолд энэ эрхээ хэрэгжүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа таван жил байна.

9.5 Энэхүү Зээлийн гэрээ нь ХБНГУ-ын хууль, тогтоомжийг удирдлага болгоно. Удирдан гүйцэтгэх газар нь Франкфурт ам Майн хот байна.

9.6 Энэхүү Зээлийн гэрээний дагуу болон холбоотойгоор үүсэх бүхий л маргаан нь зөвхөн арбитрын шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэнэ. Энэ тохиолдолд доорх зүйлүүд хамаарна:

а) Арбитрын шүүх нь нэг эсвэл гурван томилогдсон арбитрчаас бүрдэх бөгөөд тэднийг тухайн үед Олон улсын худалдааны танхимын арбитрын дүрмийн дагуу томилж, тэд үйл ажиллагаагаа уг дүрмийн дагуу явуулна.

б) Арбитрын шүүх хурал нь Франкфурт ам Майн хотод болно. Шүүх хурал Англи хэлээр явагдана.

Англи хэл дээр 2 эх хувь үйлдэв.

Улаанбаатар хот,
2019 оны 6 сарын 26

Улаанбаатар хот,
2019 оны 6 сарын 26

СБЗБ (KFW)

Монгол Улсыг төлөөлөн
Сангийн яам

Хавсралт
Хэрэгжилтийг хангах нөхцөл

Хавсралт

Хэрэгжилтийг хангах нөхцөлүүд

1. Тодорхойлолт

Хууль бусаар дарамт шахалт үзүүлэх үйлдэл/хууль бус үйлдэл: Хууль бусаар аливаа хүний эсхүл тухайн хүний өмчлөлийн үйл ажиллагаанд нөлөөлөх зорилгоор шууд болон шууд бус арга замаар хор хөнөөл учруулах эсхүл заналхийлэх үйл явцыг.

Хуйвалдсан үйлдэл: 2 болон түүнээс дээш этгээд хоорондоо үгсэн тохиролцох болон өөр бусад хүний үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг.

Авлигын үйлдэл: Аливаа хүний үйлдэл, үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох эсхүл аливаа үйлдэл эс үйлдэл хийхээс татгалзуулах зорилгоор шууд болон шууд бус арга замаар хууль бус аливаа төлбөр амлах, санал болгох, өгөх, бий болгох, шаардах, хүлээн авах, хясах болон хууль бусаар бусдад ямар нэг давуу тал бий болгох үйл явцыг.

Хууран мэхлэх үйлдэл: Аливаа үүрэг, хариуцлагаас зайлсхийх эсхүл санхүүгийн үр шим хүртэх зорилгоор тухайн хүнд буруу мэдээлэх, зориудаар эсхүл хайхрамжгүй байдлаар худал мэдээлсэн, төөрөгдүүлсэн, хуурамчаар төлөөлсөн аливаа үйлдэл эс үйлдлийг.

Хясан боогдуулсан/Саад тотгор бий болгосон үйл явц: 1) Авлигын үйлдэл, хууран мэхлэлт, хууль бус болон хуйвалдаан бүхий аливаа явцын талаарх мэдээлэл, түүнтэй холбоо бүхий мөрдөн байцаалт эсхүл мөрдөн байцаалтын явц болон мөрдөн байцаалтад хамааралтай

материалыг үзүүлэх, ил болгохоос аливаа хүнийг дарамтлах, айлган сүрдүүлэх, саад учруулах зорилгоор зориудаар мөрдөн байцаалтын нотлох баримтыг устгасан, хуурамчаар үйлдсэн, өөрчилсөн, нуусан, эсхүл мөрдөн байцаагчид худал мэдүүлэг өгсөн 2) Авлигын үйлдэл, хууран мэхлэлт, хууль бус үйлдэл болон хуйвалдааны талаарх албан ёсны мөрдөн байцаалт, хяналт шалгалттай холбоотой шаардлагатай мэдээллийг авах, энэ талаарх аливаа ажиллагаанд саад учруулах үйлдэхүйг.

Хүн/Этгээд: аливаа хүн, хуулийн этгээд, хамтарсан этгээд болон гэрээгээр тохирсон байгууллагууд

Шийтгэл хүлээх явц/байдал: Хууль бус үйлдэл, хуйвалдаан, авлига, хуурамчаар үйлдэх/мэхлэх болон хясан боогдуулсан/саад бий болгосон үйлдэл (дээр тодорхойлсон нөхцөлүүд нь (i)-д Холбооны Бүгд Найрамдах Герман улс болон бусад холбогдох хуулийн дагуу хууль бус гэж тооцогдохыг, (ii)-д эдгээр нөхцөл нь Зээлдэгч болон СБЗБ-ны хоорондын гэрээ болон тэдгээрийн хэрэгжих үйл явцын нэр хүнд эсхүл хуулийн хэрэгжилтийн явцад бодитойгоор сөрөг нөлөө үзүүлэхүйц байдал бий болгохыг.

Шийтгэл: Шийтгэл оноох эрх бүхий байгууллагаас баталж оногдуулдаг эдийн засаг, санхүү, худалдааны хууль тогтоомж, дүрэм журам болон худалдааны үйл ажиллагааг хориглосон хууль болон захиргааны арга хэмжээнүүд.

Шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллагууд: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, Европын Холбоо болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Шийтгэлийн жагсаалт: Шийтгэл хүлээх эрх бүхий байгууллагаас баталсан шийтгэл хүлээх жагсаалтад орсон тодорхой нэр заасан хүн, хуулийн этгээдийг.

2. Мэдээллийн талаар авах арга хэмжээ

Зээлдэгч нь дараах үүрэгтэй:

- a) СБЗБ-наас хүссэн, шаардсан үед хүлээн авагчийн талаарх адил төстэй мэдээлэл эсхүл «Харилцагчаа танин мэдэх» холбоотой бүхий л шаардлага, мэдээллийг өгөх
- b) СБЗБ-ны шаардлага, хүсэлтээр Зээлдэгчтэй холбоотой Төслийн мэдээлэл, баримт бичиг, түүний туслан гүйцэтгэгч

болон бусад хамааралтай талуудыг шийтгэл хүлээх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үүрэг, хариуцлагаа биелүүлэх шаардлагыг хэрэгжүүлэх, мөн түүнчлэн энэ зорилгоор Зээлдэгчийн бизнесийн харилцааг хянан шалгах үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор бүхий л холбогдох мэдээллийг ирүүлэх.

- с) Төсөлтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйлдэл, аливаа шийтгэл хүлээж болохуйц сэжиг бүхий нөхцөл байдлыг мэдсэн тохиолдолд тэр даруй, яаралтай СБЗБ -нд мэдэгдэх.
- д) Төслийн болон цаашдын үйл ажиллагааны талаар тайлан, мэдээлэл зэргийг энэхүү Хавсралтад дурдсан асуудлыг СБЗБ хэрэгжүүлэх зорилгоор хүсэлт гаргасан тохиолдолд мэдээлэх.
- е) Энэхүү Хавсралтад дурдсан асуудлаар холбогдох бүхий л Төслийн хэрэгжилтийн явцыг үзэх, айлчлах, Зээлдэгч, түүний дэд гэрээлэгч болон бусад холбогдох талуудын Төсөлтэй холбоотой баримт бичиг зэргийг ямар ч үед хянан шалгах нөхцөл бололцоог СБЗБ болон түүний томилогдсон этгээдэд хангах.

3. Төлөөлөл ба баталгаа

3.1 Холбооны Бүгд Найрамдах Германы улсын хууль болон тухайн Зээлдэгч улсын хуулийн хүрээнд Зээлдэгчээс ямар ч хүн Төслийн болон Хүлээн авагчийн өмнөөс шийтгэл хүлээж болохуйц нөхцөл, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй гэдгээ мэдэгдэж, үүрэг хүлээнэ.

3.2 Энэ зүйлд дурдсан төлөөлөл болон баталгаа нь энэхүү гэрээг хэрэгжүүлэх зорилгоор анх удаа хийгдсэн. Энэхүү нөхцөл нь санхүүгийн хувь нэмэр/санхүүжилт хийх тохиолдол бүрт давтагдах бөгөөд тухайн нөхцөлд тухайн цаг хугацаандаа давамгайл үйлчилнэ.

4. Эерэг түвшинд авах арга хэмжээ

Зээлдэгчээс хэрэв тухайн Зээлдэгч эсхүл СБЗБ аливаа шийтгэл хүлээх нөхцөл байдал, мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоо бүхий сэжигтэй нөхцөл бий болсон нөхцөлд тэр даруй СБЗБ болон түүний томилсон этгээдтэй тухайн тохиолдол үүссэн эсэх асуудлыг шийдвэрлэхээр бүрэн хамтран ажиллах арга хэмжээг авна. Ялангуяа



Зээлдэгчээс СБЗБ руу бүхий л дэлгэрэнгүй мэдээллийг тэр даруй хүргүүлэх, мэдээлэх арга хэмжээг авна. Мөн СБЗБ-ны хүсэлтээр холбогдох баримт бичгийг явуулах үүргийг хүлээнэ.

5. Сөрөг түвшинд авах арга хэмжээ

Зээлдэгч нь шийтгэл хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн, зөрчсөн Төсөлтэй холбоо бүхий бусад аливаа арга хэмжээ, харилцаа, гүйлгээнд орж болохгүй.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

Индекс: 200003